

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН МӨНХБАТЫН ЭРДЭНЭБОЛДЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “2024 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын гүйцэтгэлийг хангаж ажиллах зорилтын хүрээнд”							
1.	Арга хэмжээ 1.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх барилга угсралт, засварын ажлын зураг төслийг гүйцэтгүүлж хүлээн авах	Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ажлын зураг төсвийг гүйцэтгүүлэн хүлээн авсан байх.	4	Улс, орон нутгийн 48 төсөл арга хэмжээ	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх барилга угсралт, засварын 38 ажлын зураг төслийг хүлээн авсан бөгөөд 8 сумын инженерийн шугам сүлжээний зургийн даалгаварыг боловсруулах үйлчилгээг Эдийн засаг, хөгжлийн яамнаас зохион байгуулаад байна.	2024.03.01- 2024.12.30	90%
2.	Арга хэмжээ 1.2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 эхлэх барилга угсралт, засварын ажлын зураг төсвийг Худалдан авах ажиллагааны газарт	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 25 барилга угсралтын төсөл арга	-	Улс, орон нутгийн нийт 53 төсөл арга хэмжээ	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга угсралтын 25 төсөл арга хэмжээний ажлын зураг төслийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газарт хүлээлгэн өгсөн. Тухайн төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг зохион байгуулан	2024.01.02- 2024.12.30	100%

	хүлээлгэн өгч худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах дэмжлэг үзүүлэх	хэмжээ, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга угсралт, засварын 28 төсөл арга хэмжээний зураг төсвийг хүлээлгэн өгсөн байх			гүйцэтгэгчийг шалгаруулсан байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга угсралтын 2, засварын ажлын 18 төсөл арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга угсралтын 3, засварын ажлын 5 төсөл арга хэмжээний ажлын зураг төслийг хүлээлгэн өгсөн бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх БОЭТ-ийн Төрөх, эмэгтэйчүүдийн эмнэлгийн гадна фасадны засвар, Гэмтэл, яаралтай тусламж, хөнгөвчлөх эмчилгээний тасгуудыг цахилгаан шаттай болгох, Нийтийн эзэмшлийн зам талбайн дүүргэлт болон 4, 12, 9-р багуудын үерийн усны шуудуу эдгээр ажлуудын худалдан авах ажиллагааг 4-5 удаа зохион байгуулсан ч оролцогчгүй ороогүйн улмаас хүчингүй болсон байна.		
Зорилт 2. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд”							
1.	Арга хэмжээ 2.1. Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах	-Үүрэг даалгаврын биелэлтээр	-	100%	Өдөр тутмын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, ёс зүй, сахилгыг чанд мөрдөж албан үүргээ цаг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, салбарын тоон мэдээлэл, судалгааг цаг тухай бүр шинэчлэн удирдлагыг салбарын мэдээллээр хангаж ажиллаж байна.	2024.01.02-2024.12.30	100%
2.	Арга хэмжээ 2.2. Албан бичиг болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн	-Албан бичиг, өргөдөл, гомдлын	-	100%	Хэлтсийн албан бичиг хөтлөлтийг хэрэгжүүлж байгаа бөгөөд удирдлагуудаас шилжин орж ирж буй өргөдөл, албан бичгийг мэргэжилтэнгүүдэд хүлээлгэн өгч байна.	2024.01.02-2024.12.30	100%

	хэрэгжилтийг хангаж ажиллах	шийдвэрлэлтийн хувиар			Өөрийн хариуцсан салбарын хүрээнд Арвайхээр сумын иргэн О.Баярсайханы нийтийн орон сууцны барилга барихтай холбоотой барилгын эскиз зураг батлуулах, иргэн Б.Юмжирдуламын гэрлүү үерийн ус орж өөрийн өмч хөрөнгөд хохирол учруулж байгаатай холбоотой, Улаанбаатар хотоос Арвайхээр суманд шилжин ирж буй иргэн Б.Хашбатын нийт 3 өргөдөл ирсэнийг мөн бусад албан бичгүүдийг тухайн бүрт нь шийдвэрлэн ажилласан.		
3.	Арга хэмжээ 2.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	-Архив, албан хэргийг холбогдох хууль, журам, заавар, стандартын хэрэгжилтээр	-	100%	Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Хугацаатай болон бусад албан бичгийг цохолт хийгдсэн албан хаагчдад тухай бүрт нь хүргүүлж заасан хугацаанд нь шийдвэрлүүлэх хэлтсийн даргын тавьсан үүргийн хэрэгжилтийг холбогдох албан тушаалтанд эргэн мэдээлэх үр дүнг тайлагнаж ажиллахыг дамжуулан ажиллав.	2024.01.02-2024.12.30	100%

1.	Арга хэмжээ 2.1. Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	Сургалтад амжилттай суралцсан байх	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтанд амжилттай хамрагдан сертификат авсан.	Эхний хагас жилд 100%-д хүрэх	Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад хамрагдсан бөгөөд зарим хичээлүүд дээр амжилтгүй суралцсан тул сертификат олгогдоогүй байна.	2024.01.02 - 2024.06.10	50%
2.	Арга хэмжээ 2.2. Байгууллагаас болон бусад холбогдох газруудаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт хамрагдсан байх	Сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэгт хамрагдсан байдал	-	Жилийн эцсийн байдлаар 5-с доошгүй сургалтад хамрагдсан байх	“Барилгын чанар, аюулгүй байдал сэдэв”-т Өвөрхангай аймгийн барилгын салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн-2024” 4 дүгээр сарын 12-15-ны хооронд зохион байгуулагдсан сургалтад амжилттай хамрагдсан. Улаанбаатар хотноо 1 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан Хангайн бүсийн урьдчилсан хэлэлцүүлэг болон 2 дугаар сарын 1-2 хооронд зохион байгуулагдсан Монголын эдийн засгийн чуулган-Бүсчилсэн хөгжил Хангайн бүсийн салбар хуралдаанд оролцсон. 10 дугаар сарын 26-ны өдөр “Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулган-2024”	2024.01.02-2024.12.30	100%

					оролцлоо. 11 сарын 04, 05-ны өдрүүдэд Удирдлагын академиас ажлын байран дахь “Монгол Улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт-сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт богино хугацааны сургалт, 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол Улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт: Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл сэдэвт цахим, танхим хосолсон 16 цагийн хичээлд амжилттай хамрагдлаа. Сургалтад хамрагдсанаар төрийн албан хаагчид зөв бодлого боловсруулах, багийн хамтын ажиллагаа, шударга ёс, ил тод байдлын бие даасан хяналт бүхий сэтгэлгээний чадвар дээшлэн, хэнийг ч орхигдуулахгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, оролцоо үе хоорондын тэгш байдлыг хангах зэргээр мэдлэг, ур чадвараа нэмэгдүүллээ.		
--	--	--	--	--	---	--	--

3.	Арга хэмжээ 2.3. Монгол бичгийн дунд шатны сургалтад хамрагдаж, албан бичиг боловсруулах	Албан бичиг боловсруулсан байх	Монгол бичгийн анхан шатны сургалтад хамрагдсан	Тухайн жилийн хугацаанд 2-доошгүй албан бичиг боловсруулсан байх	Удирдлагын академиас 05 дугаар сарын 14-20 өдрүүдэд цахимаар зохион байгуулсан монгол бичгийн дунд шатны 40 цагийн цахим хичээлд амжилттай оролцож үнэмлэх авсан. Монгол бичгээр албан бичиг гаргаагүй байна.	2024.01.02 - 2024.12.30	70%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Газрын харилцаа, хот байгуулалтын
асуудал хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

М.Эрдэнэболд / *М. Эрдэнэболд* /

(Нэр, гарын үсэг)

2024 оны 12 дугаар сарын 05

(Огноо)